

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	21
5. Аудитын хураангуй тайлангийн хавсралт.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ШИНЭ ЭХЛЭЛ
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

2020.02.21 № 06/584
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн санхүүгийн тайланд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн номын фондын дүн номын сангийн бүртгэлээс 43,093.8 мянган төгрөгийн 4462 ширхэг номоор дутуу илэрхийлэгдсэн,
- Тайлант хугацаанд улсын төсөвт төвлөрүүлэх өөрийн орлогын төлөвлөгөөг батлуулаагүйгээр 21,968.1 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан,
- Нэмэлт төсвийн данснаас арилжааны банкны картын дансаар дамжуулан оны эцэст 5,013.3 мянган төгрөгийг ажлын хөлсөнд олгосон зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Н.Оюунгэрэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орлогын төлөвлөгөө батлуулах, орон тооны жишиг нормативыг мөрдөж ажиллах, хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөх, анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 29-нөөс 2020 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ц.Энхжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02/01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, үнэт зүйл бүхий, хүмүүнлэг, монгол иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль нь Бага, суурь, бүрэн дунд боловсролын судалгаа, шинжилгээ, туршилт, ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөрөөр хос хэлний сургалт эрхлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургууль нь БСШУСС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг бөгөөд Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлтийг мөрдөн ажиллаж байна.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Тус сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 988,734.7 мянган төгрөгөөс тооцон 9,887.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тогтоохдоо материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөөгүйгээр тайлант үеийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сууриар сонгон 11,014.0 мянган төгрөгөөр тогтоосон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,906.4 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	143,491.2	131,477.6	-12,013.7
Үндсэн хөрөнгө	1,666,659.6	1,632,766.9	-33,892.7
Нийт хөрөнгийн дүн	1,810,150.8	1,764,244.5	-45,906.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,810,150.8	1,764,244.5	-45,906.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,810,150.8	1,764,244.5	-45,906.4

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал,

Бараа материалын дансны үлдэгдэл 12,013.7 мянган төгрөг буюу 8.4 хувиар буурсан нь тусгай зориулалт, бичиг хэргийн материалыг сургалтын үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 45,906.4 мянган төгрөг буюу 2.5 хувиар буурчээ. Тус сургууль нь БСШУСЯ-наас үнэ төлбөргүйгээр 22,167.8 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч, 11,547.7 мянган төгрөгийн тавилга, ном, сурах бичгийг худалдан авсан байна. Тайлант хугацаанд 67,608.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь үндсэн хөрөнгө дансны дүн буурахад голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд санхүүгийн үр дүн 45,906.4 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль нь тайлант онд өөрийн орлогын төлөвлөгөө батлуулаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,008,078.8 мянган төгрөгийн урсгал зардлын төсвийг санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч урсгал зардалд 944,479.1 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл 63,599.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардал 944,479.1 мянган төгрөг буюу 93.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь тус сургуулийн барилгын өргөтгөлийн ажлыг улсын комисс 10 дугаар сард хүлээн авсантай холбоотойгоор байр ашиглалтын тогтмол зардлаас 10,279.2 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 46,276.6 мянган төгрөг, захирал болон дотоод хяналтын ажилтан, жижүүрийн орон тоо дутуу ажилласнаас цалингийн зардлаас 3,833.1 мянган төгрөг, бусад зардлаас 3,210.8 мянган төгрөг зарцуулагдаагүй үлджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Тус сургууль нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд 22,152.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэн нэмэлт төсвийн дансаар дамжуулан зарцуулсан байна. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 13,425.0 мянга, хангамж бараа материалын зардалд 7,602.9 мянга, урсгал шилжүүлэгт 900.0 мянга, нийт 21,927.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 224.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 172,163.6 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 22,167.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 15,088.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 134,907.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Тус сургууль нь өөрийн байранд үйл ажиллагаагаа явуулж байна. Тус барилга нь үл хөдлөх эд хөрөнгийн болон газар эзэмших улсын бүртгэлийн гэрчилгээгүй байна.

Энэ нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.2, ... 8.1.9-д заасан эрх нь эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ", Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6-д "Боловсролын сургалтын байгууллага нь барилга, хот төлөвлөлтийн норм, нормативыг баримтлан тогтоосон, сургалтад зориулсан эзэмшил газартай байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд бүртгэлтэй барилга, байгууламжийн үл хөдлөх эд хөрөнгийн болон газрын улсын бүртгэлийн гэрчилгээг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлүүлэх талаар аудитын төлөвлөлтийн үе шатанд албан шаардлага хүргүүлэв.

2. Боловсролын тухай хуулиар бүтэц зохион байгуулалтыг Удирдах зөвлөлөөр батлуулахаар заасан боловч тус сургуулийн Захирлын үүргийг түр хавсран гүйцэтгэгч 2019 оны А/01 дүгээр тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна.

Энэ зөрчил нь Боловсролын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т “Боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг ... төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль, улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий боловсролын сургуульд, ... удирдах зөвлөл тус тус хэрэгжүүлнэ”, 36 дугаар зүйлийн 36.12-т “Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 36.12.2-т “сургуулийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн нийт хэмжээг тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг удирдах зөвлөлөөр батлуулах талаар аудитын төлөвлөлтийн үе шатанд албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант хугацаанд төрийн сангийн данснаас арилжааны банкны картын дансаар дамжуулан 19,088.4 мянган төгрөгийн гүйлгээг хийснээс 15,088.4 мянган төгрөгийн гүйлгээний кассын тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 7.2-д “Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж ... нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна” гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Арилжааны банкны төлбөрийн картын дансаар дамжуулан зарцуулсан ажил гүйлгээ бүрийг бүртгэн, кассын тайлан бэлтгэж байх талаар албан шаардлага хүргүүлсэн.

4. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн хандив тусламжийн орлогын дүн, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн хандиваар авсан дүнгээс 22,167.8 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайланг залруулав.

Аудитаар илэрсэн 134,907.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах дараах асуудлуудыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. БСШУСЯ-ны захиалгаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан 1,093,677.1 мянган төгрөгийн барилгын өргөтгөлийн ажлыг санхүүгийн тайланд бүртгэсэн эсэх,
2. Цалингийн нэмэгдлийн тооцооллыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу олгож байгааг нягтлах, цагийн бүртгэлтэй тулган давтан тооцоолох,
3. Үндсэн болон туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогын зарцуулалтыг хянах,
4. Тайлант оны түлш, шатахууны зардлыг шатахууны үлдэгдэлтэй харьцуулан үнэлэх, /тайлант хугацаанд 2,041.1 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, 5,823.7 мянган төгрөгийн шатахууны үлдэгдэлтэй байна. Энэ нь тус сургуулийн 2 жил орчмын шатахууны нөөц/.

Мөн хөрөнгийн тооллогыг чанартай хийж, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгах, хөрөнгийн нэр төрөл, тоо ширхэг, ангиллыг зөв бүртгэх, хөрөнгийг коджуулах,

шатахууны картын урамшууллыг данс бүртгэлд бүртгэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Ажил олгогчийн буруугаас ажлаас чөлөөлөгдсөн нэг ажилтанд шүүхийн шийдвэрээр 6,346.4 мянган төгрөгийн нөхөн олговор олгосныг буруутай албан тушаалтнаар төлүүлэх албан шаардлагыг дээд шатны төсөв захирагчийн дотоод аудитын нэгжид хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 3 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,999.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эхлэл сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэлийг Аудитын гэрчилгээний аудитын гол асуудал хэсэгт тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд өөрийн орлогын төлөвлөгөөг батлуулаагүйгээр элсэлтийн шалгалтын хураамж, сурах бичгийн түрээсийн орлого, цайны газрын түрээсийн орлогын 21,968.1 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4.2-д "төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.3-т "үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах" гэж заасныг тус тус мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, үргүй зардал гарах.

1.3. Өгсөн зөвлөмж:

Жилийн төсвийн төслийг боловсруулахдаа төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоог хийж батлуулж байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт

Тайлант онд тус сургуулийн захирал нь ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад ажилтны орон тооны жишиг нормативд заагаагүй 6 орон тоог нэмж батлан ажиллуулж 48,503.6 мянган төгрөгийн цалинг олгосон байна. Үүнд: нарийн бичиг, IT инженер, дотоод хяналтын ажилтан, эмч, лаборант, жолооч, сантехникч болно.

Энэ нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10-д "Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багтаамж ... багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг боловсролын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална", БСШУСС, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Орон тооны жишиг норматив батлах тухай" хавсралтын 2-д "Ерөнхий боловсролын сургууль /1-12 дугаар ангитай, 10-12 дугаар ангитай/ 161-320 суралцагчийн тоонд хамаарах албан тушаалтны жагсаалт..."-тай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл

Цалингийн сан буруу төлөвлөгдөх, орон тоо илүү ажиллуулах, үргүй зардал гарах;

2.3. Өгсөн зөвлөмж

Ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг мөрдөж ажиллах;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн номын фондын дүн номын сангийн бүртгэлээс 43,093.8 мянган төгрөгийн 4462 ширхэг номоор дутуу илэрхийлэгдсэн;

Жилийн эцсийн бараа материалын тайлангийн үлдэгдлээс 14 нэр төрлийн 128 ширхэг бараа материалыг түүвэрлэн шалгахад 3 нэр төрлийн 9,041.8 мянган төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр, өөр нэрээр бүртгэсэн;

Хөрөнгийн тооллогоор 2,745.7 мянган төгрөгийн 3 ширхэг компьютер дутсан ба тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "... ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө шамшигдах, үрэгдэх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг анхан шатны баримт үндэслэн орлогод авах, тооллогыг үнэн зөв чанартай хийж, үр дүнг санхүүгийн тайланд тусгах, бүртгэлгүй ном, тооллогоор дутсан компьютерыг өмч хамгаалах комиссоор хэлэлцүүлэн шийдвэрлэх, буруу бүртгэсэн бараа материалын нэршил тоо ширхгийг залруулж бүртгэх;

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 2,041.1 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоо хийгээгүй, шатахууныг бөөн дүнгээр бүртгэсэн, жолоочийн тооцооны хуудсыг тухай бүр гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "... эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, ... зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.2 Эрсдэл:

Санхүүгийн үр дүн, бараа материалын тайлан буруу илэрхийлэгдэх, зардал хүлээн зөвшөөрөгдөхгүй байх.

4.3 Өгсөн зөвлөмж:

Шатахуун зарцуулалтын тооцоог анхан шатны баримтыг үндэслэн хийх, жолоочийн тооцооны хуудсыг хөтөлж хэвших;

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5 Дотоод хяналттай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Нэмэлт төсвийн данснаас арилжааны банкны картын дансаар дамжуулан оны эцэст 5,013.3 мянган төгрөгийг ажлын хөлсөнд олгосон,

Сургуулийн автобусны моторыг солихдоо техникийн комиссын актгүйгээр оны эцэст 2,500.0 мянган төгрөгийн гэрээг байгуулан, тухайн өдөр ажил үйлчилгээний төлбөрийг олгосон байна.

